



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/234

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 126 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Залуучуудын хөгжлийг дэмжих" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд "Хүүхдийн төлөвшилтөд багш нарын оролцоо" сургалт зохион байгуулах зардалд 8 180 000 төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх үйл ажиллагаануудад шаардагдах 8 180 000 төгрөг /найман сая нэг зуун наян мянган/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний 4.7-д тусгагдсан "Залуучуудын хөгжлийг дэмжих" хөтөлбөрийн зардлаас хавсралтын дагуу санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/234 Ch
02. 01153